



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

II ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хурлыг 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 13:30 цагт Төрийн ордон дахь "Нутгийн удирдлагын танхим"-д 89 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын онцгой комиссын үйл ажиллагаа:

*Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
бригадын генерал Г.Ариунбуян,*

2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн хоёрдугаар хагасын хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх талаар;

*Боловсрол, шинжлэх ухааны сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн  
Л.Энх-Амгалан,*

3. Өвөлжилтийн нөхцөл байдлын талаар;

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан,*

4. Газар хөдлөлтийн нөхцөл байдлын мэдээлэл;

*ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн  
захирал, академич С.Дэмбэрэл,*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг: Улсын онцгой комиссын гишүүд.

Эрүүл мэндийн яамны улсын албаны  
Шуурхай штабын дарга, хурандаа Б.Ууганбаяр.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,  
Нийслэлийн онцгой комиссын дарга Д.Сүмъяабазар нарт.

1.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны Шуурхай штабын бүтэц, ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн боловсруулж, батлуулах;

1.2. Мэргэжлийн байгууллага, аймаг, нийслэлийн онцгой комисс, Шуурхай штабууд коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтыг тогтоох, хумих талаар тандалт судалгаа, хариу арга хэмжээний төлөвлөлтийг боловсруулж Улсын онцгой комисст танилцуулах;

1.3. Эх орондоо ирэх хүсэлт гаргасан гадаад улсад байгаа иргэдийг татан авах төлөвлөгөөг боловсруулж, танилцуулах;

1.4. Тусгаарлан ажиглах байрны орчин нөхцөлийг сайжруулах, ариутгал, халдваргүйтгэл, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар заавар зөвлөгөө, тогтмол өгч ажиллах.

Хоёр. Боловсрол, шинжлэх ухааны сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Л.Энх-Амгалан.

Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт:

2.1. Коронавируст халдвар (КОВИД 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн хоёрдугаар хагас жилийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн теле болон цахим хэлбэрээр, 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс танхимын сургалтыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангуулах;

2.2. Теле болон цахим хичээлийг гэрийн орчинд үзэх техникийн боломжгүй сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд сургалтын гарын авлага, хэвлэмэл болон бусад материалыг хүргэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах.

Гурав. Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд.

Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт:

3.1. Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтэнүүдийн мэргэшлийн судалгааг гаргах, эмч, ажилчдыг сургаж чадавхжуулах, ажлын үүрэг хариуцлагыг чангатгах;

3.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын шинжилгээ авах оношлуур, урвалж бодисын нөөцийг нэмж бүрдүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

3.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакциныг Монгол Улсад оруулж ирэх ажлыг шуурхай зохион байгуулж, вакцинаар дархлаажуулах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах бэлтгэл ажлын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг Улсын онцгой комисст танилцуулах;

3.4. Эрүүл мэндийн байгууллагын хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх.

Дөрөв. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Х.Лхагвасүрэн,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт нарт;

4.1. Хилийн Цагааннуур боомтоор малын тэжээл импортлох асуудлыг судлаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх.

Тав. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт;

5.1. Улаанбаатар хотоос гарах, орох хөдөлгөөний зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн цахим санг бүрдүүлэх;

5.2. Орон нутагт зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтыг сайжруулах, халдвар хамгааллын болон хорио цээрийн дэглэмийг чанд сахиулах арга хэмжээг зохион байгуулах;

5.3. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах чиглэлээр мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, ухуулах хуудас зэргийг бэлтгэн нийтийн эзэмшлийн гудамж, талбай, нийтийн тээвэр болон олон нийтийн үйлчилгээний газраар зорчих иргэдэд түгээж, сурталчлах.

Зургаа. Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэлд:

6.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, бэлэн байдлыг хангах, эрт зарлан мэдээлэх тогтолцоог сайжруулж, иргэдэд шуурхай хүргэх боломжийг судлах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулж Улсын онцгой комисст 2021 оны 2 дугаар сард багтаан танилцуулах.

Долоо. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Захирал Д.Наранзүл,

Зооноз өвчин судлалын үндэсний төвийн захирал Н.Цогбадрах нарт:

7.1. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийн чанарт тавих хяналтыг чангатгах.

7.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын тохиолдол болон батлагдсан тохиолдлын тандалтын мэдээллийг тухай бүр Мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлж, хамтран ажиллах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

УХАД158

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
ДЭД ХУРАНДАА

Т.МӨНХДОРЖ